



1-р улирлын тайлан

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН  
АЖЛЫН ТАЙЛАН**

Хугацаа: 2014 оны 8-р сарын 28-наас  
2015 оны 3-р сарын 31.

Улаанбаатар хот  
2015 он



## Оришил

2013 оны байдлаар Хөдөө аж ахуйн салбар ДНБ-ий 14.8 хувийг эзэлж байгаагаас Мал аж ахуйн салбар түүний 88 орчим хувийг нь бүрдүүлж байна. Монгол Улсын нийт ажиллах хүчний 38 хувь нь Мал аж ахуйн салбараас шууд хамааралтай бөгөөд ажил эрхлэлтийн хувьд улс орны эдийн засгийн чухал салбар юм. Мал аж ахуйн салбар нь бэлчээрийн нөхцлөөс хамаарч бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд байгаль цаг уурын эрсдэлт байдлаас хараат байдаг эмзэг салбар болно.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран 2005 оноос Малын Индексжуулсэн даатгал төслийг хэрэгжүүлж эхэлсэн ба 2012 онд үндэсний хэмжээнд буюу Монгол Улсын бүх аймаг, нийслэл хотод малын эрсдэлийн даатгалын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. Төслийн зорилго нь Малын эрсдэлийн даатгалын тогтолцоог Засгийн газрын оролцоотойгоор үндэсний хэмжээнд нэвтрүүлэх, даатгалын оновчтой бүтцийг бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршиж байгаа ба малчин өрхүүдийн гамшгаас үүсэх их хэмжээний малын хорогдолтой холбоотой эдийн засгийн эмзэг, хараат байдлыг бууруулах нь төслийн үр дүн юм.

2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр УИХ-аар “Малын индексжуулсэн даатгалын тухай хууль” батлагдсанаар Малын Индексжуулсэн даатгалын тогтолцоог цаашид тогтвортой үргэлжлүүлэх хууль эрх зүйн орчин бүрдлээ.

### **“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК үүсэл, хөгжил:**

1. Малын индексжуулсэн даатгалын тухай хуулийн 17, 18.1, 19.1.1 дэх зүйл заалтуудын хэрэгжилтийг ханган 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Засгийн газрын 280 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай хувьцаат компанийг үүсгэн байгуулав. Ингэснээр “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь МИД төслийн үйл ажиллагааг орон даяар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр боллоо.
2. Сангийн сайдын 2014 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 192 тоот тушаалаар компанийн дүрмийг баталж, санхүүжилтийг шийдвэрлэв. Мөн Сангийн сайдын 2015 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 35 тоот тушаалаар компанийн дүрмийг боловсронгуй болгон шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Компанийн дүрэмд эрхэм зорилго, зорилтоо тодорхойлон үйл ажиллагааны зохицуулалтаа тусган баталгаажууллаа.
3. Өнгөрсөн хугацаанд ТУЗ-ийн хурал 8 удаа хуралдаж, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч нарыг томилох, бизнес төлөвлөгөө батлах, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөө батлах зэрэг зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн асуудлаар 25 тогтоол гарган хэрэгжүүлж байна.
4. ТУЗ-ийн 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 02/02 тоот тогтоолоор компанийн лого, тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсын загварыг батлав.
5. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж, байгууллагын 5885612 тоот регистрийн дугаар бүхий гэрчилгээ



авлаа. Мөн 2014 оны 10 дугаар сарын 6-ны өдөр Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст бүртгүүлэв.

6. Улсын төсвөөс 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Алдагдлаас хамгаалах сангийн 5 тэрбум төгрөг, 2014 оны 10 дугаар сарын 15-ны өдөр дүрмийн сангийн хөрөнгийн 15 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүллээ.
7. ТУЗ-ийн 2014 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/07 тоот тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн бизнес төлөвлөгөөг батлав. Бизнес төлөвлөгөөнд компанийн алсын хараа, бүтэц орон тоо, дунд хугацааны санхүүгийн, хөрөнгө оруулалтын, давхар даатгалын төлөвлөгөө, эрсдэлийн шинжилгээг тусгасан байна. Компанийн бүтэц, орон тоог хавсралтаар харуулав. Компанийн бизнес төлөвлөгөөг 5-р сард шинэчлэн батлуулахаар ажиллаж байна.
8. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 48 тоот тогтоолоор компанийд давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.
9. Гүйцэтгэх захирал нь эрх хэмжээний хүрээнд компанийн хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журам, ажлын төлөвлөгөө батлах, ажилтан томилох зэрэг компанийн дотоод зохион байгуулалттай холбоотой 24 тушаал гаргасан байна.
10. Компанийн үйл ажиллагааг тогтвортжуулах зорилгоор 186 м<sup>2</sup> талбай бүхий оффисын байрыг түрээслэн тусгай өрөө гаргах, албан ажлын хэрэгцээний суудлын автомашин, компьютер, техник хэрэгсэл, ширээ сандал худалдан авах, интернет сүлжээнд холбогдох зэрэг бараа, ажил, үйлчилгээ худалдан авч материаллаг баазаа бэхжүүлж, ажилтнуудыг ажиллах хэвийн нөхцөлөөр хангалаа.

#### **Давхар даатгалын газрын үйл ажиллагааны хүрээнд:**

Давхар даатгалын газар нь газрын дарга, андеррайтер, даатгалын шинжээч зэрэг орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Оролцогч даатгагч болон даатгуулагч нарын хооронд байгуулагдах “Малын индексжуулсэн даатгал”-ын гэрээний загварыг МИД төслийн хуульч, олон улсын хуулийн зөвлөхтэй хамтран боловсруулж, ТУЗ-ын 2 сарын 11-ний өдрийн 4-р хуралдаанаар батлуулав.
2. Оролцогч даатгагч нараас санал авсны үндсэн дээр нөхөн төлбөрийн доод хэмжээг 20 хувь байсныг өөрчлөн малчны телсөн хураамжийн 35 хувь буюу цэвэр хураамжийн 50 хувиар тооцож олгож байхаар тогтов. Нөхөн төлбөрийн доод хэмжээ нь хэт бага нөхөн төлбөр олгох байдлыг зассан ойлголт юм.
3. Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн 2014 оны жилийн эцсийн малын тоо, сар бүрийн малын дундаж үнийг тооцоолон бодож 2015 оны борлуулалтын улиралд ашиглах малын үнийг гаргаж оролцогч даатгагчид болон даатгалын төлөөлөгч нарт мэдээллэв.



4. МИД-ын босго үзүүлэлтийг Засгийн газраас тогтоож байхаар “Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль”-д заасны дагуу тогтоолын төслийг бэлтгэн боловсруулж, Засгийн газрын 3 дугаар сарын 30-ны өдрийн 123 тоот тогтоолоор батлууллаа.
5. Оролцогч даатгагч нарын актуарч нарт МИД-ын хураамжийн хувийг тооцоолох аргачлалын талаар сургалт хийж, Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн 2014 оны жилийн эцсийн малын тоо, хорогдлын мэдээ, малтай өрх болон малчин өрхийн тоо зэрэг шаардлагатай тоо мэдээллүүд дээр тооцоолол хийлгэн хураамжийн хувийг тооцуулахад 2014 онд ашигласан хураамжийн хувиас маш бага зөрүүтэй дүн гарсан тул оролцогч даатгагч нар санал нэгтгэйгээр 2015-2017 онд 2014 оны борлуулалтын улиралд ашигласан хураамжийн хувийг ашиглахаар тогтов.
6. 2015 оны МИД-ын борлуулалтын улиралд оролцох эсэх талаар санал авах албан захиаг 2014 онд МИД төсөлд оролцсон 7 даатгалын компанид хүргүүлэхэд “Номин даатгал” ХХК энэ удаагийн борлуулалтанд оролцохоос татгалзаж, “Бодь даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК болон “Тэнгэр даатгал” ХХК-үүд оролцох тухай албан хүсэлтээ ирүүлсэн. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон дээр дурьдсан оролцогч 6 даатгалын компани хооронд “Алдагдлыг зогсоох давхар даатгалын гэрээ”-г 2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр байгууллаа.
7. МИД-ын борлуулалтанд оролцохоор гэрээ байгуулсан 6 даатгалын компаниас борлуулалтын төлөвлөгөө боловсруулан гаргуулж аван нэгтгэхэд 17230 малчин өрхийг даатгалд хамруулж 1 тэрбум 480 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлэхээр байна. Оролцогч даатгагчийн борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн давхар даатгалын хураамжийн урьдчилгааг тооцон Хөдөө аж ахуйн давхар даатгал ХК-ийн дансанд төвлөрүүлээд байна.
8. Санхүүгийн зохицуулах хорооноос “Хамтын эрсдэлийн сан”-гийн журам болон “МИД-ын хураамж”-ын журмыг гаргахад шаардлагатай тоо мэдээллээр хангаж, санал авах уулзалтуудыг зохион байгуулж ажиллав.
9. МИД-ыг зуучлан борлуулах банкыг сонгон шалгаруулахаар хөдөө орон нутагт хамгийн олон салбар нэгж бүхий ХААН банк, Төрийн банкууд руу хүсэлт тавьсан бөгөөд ХААН банкны зүгээс 2015 онд зуучлагчаар ажиллахаар татгалзсан. Харин хураамжийн зээл болон хөнгөлөлттэй зээлийг өнгөрсөн онуудад МИД төсөлтэй хамтран ажиллаж байсан жишгээр цаашид “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-тай үргэлжлүүлэн ажиллахаар болсон. Төрийн банкны зүгээс МИД-ыг зуучлан борлуулагчаар ажиллахаас гадна, малчдад хураамжийн зээл болон хөнгөлөлттэй зээл олгож ажиллахаар “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон оролцогч даатгагч нартай “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулаад байна. Мөн энэхүү гэрээний хүрээнд “МИД-ын зуучлагчаар ажиллах журам” гарган холбогдох талуудад хүргүүлээд байна.



10. Оролцогч даатгагч нарын гаргасан борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн оролцогч даатгагч нарын зардлаар нийт 44000 ширхэг МИД-ын баталгааг өгсөн загвараар хэвлүүлэх үнийн саналыг хэвлэлийн компаниудад хүргүүлэн, хэвлэхээр шалгарсан “Мөнхийн үсэг” ХХК-аар хэвлүүлж, орон нутаг, даатгалын төлөөлөгч наарт хүргүүлэх ажлыг зохион байгуулаа.
11. МИД-ын борлуулалтын бэлтгэл ажлын хүрээнд МИД-ын програм хангамжийг бэлтгэх, сайжруулах тал дээр холбогдох тоон мэдээллүүд, даатгалын төлөөлөгчдийн нэрсийг МИД ТХН-ийн мэдээллийн системийн мэргэжилтнүүдэд бэлтгэн өгч, бүртгэл тооцооллын алдаагүй хэвийн ажиллах тал дээр хяналт тавин ажиллаж байна. Мөн зуучлагчаар оролцож буй банкны системтэй холбогдон ажиллуулахад талуудыг холбон, санал зөвлөмж өгөн ажиллаж байгаа болно.
12. Борлуулалтыг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх ажлын хүрээнд цаг тооны бичиг, МИД-ын товхимол, танилцуулга брошур болон малчдын сонины эхийг бэлтгэж хэвлүүлэн оролцогч даатгагч, даатгалын төлөөлөгч нараар дамжуулан орон нутагт түгээгээд байна.
13. Оролцогч даатгагч нарын гаргасан борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн давхар даатгалын хураамжийн урьдчилгааг аваад байгаа бөгөөд давхар даатгалын тодорхой эрдсэлээ олон улсын давхар даатгагч наарт шилжүүлэх үүднээс холбогдох тооцооллуудыг хийж, үнийн санал авахаар бэлтгэж байна.

**Бизнес хөгжил, төслийн газрын үйл ажиллагааны хүрээнд:**

Бизнес хөгжил төслийн газар нь газрын дарга, актуарч, эрсдэлийн шинжээч, төсөл санхүүжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Гадаадын давхар даатгалын асуудлаар Дэлхийн банкны судалгаатай танилцах, Канад Улсын Саскатчеван мужийн хөдөө аж ахуйн давхар даатгалын тогтолцооны туршлагыг судлах талаар бэлтгэл ажлыг ханган холбогдох материалыудыг боловсруулаад байна.
2. 2015 оны МИД-ын борлуулалтын үеийн сурталчилгаа хийх ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/22 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн танилцуулга, гарын авлагыг 20000 ширхэгийг хэвлэж оролцогч даатгалын компаниудад хүргүүллээ. МҮОНТ-ийн “News” агентлагтай гэрээ байгуулан телевизийн нэвтрүүлэг хийх, шторк түгээх зэрэг сурталчилгааны ажлыг эхлүүлэхэд бэлэн боллоо.
3. Малын индексжуулсэн даатгалын тухай болон компанийнхаа тухай мэдээллийг малчдад тухай бүрд нь хүргэж, даатгалын ашиг тусыг сурталчлах зорилгоор “Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал” ХК нэртэй фэйсбуук пэйж нээн ажиллуулж эхэллээ. Илүү олон малчдад хүрэхийн тулд 21 аймгийн олон хандалттай пэйж



хуудсуудтай хамтран ажиллах санал тавин, тодорхой хуудсууд дээр өөрсдийн мэдээллээсээ нийтэлж байна.

4. Жил бүрийн МИД-ын борлуулалтын улирал, авто оношлогоо эхлэхээс өмнө Монголын даатгагчдын холбоо болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран “Даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт”-ыг зохион байгуулж байна. 2015 оны 03-р сарын 20-ноос 04-р сарын 10-ны хооронд 21 аймаг, Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй энэхүү сургалтанд МИД-ын талаар болон шинээр батлагдсан хуулийн талаар сургалт хийлгэхээр тохиролцон шаардлагатай сургалтын материалыудыг бэлтгэж өглөө. Шалгалтын дүн болон шинээр даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл авсан даатгалын төлөөлөгчдийн нэрсийг СЗХ-ноос хүлээж байна.
5. Компанийн ажилтнуудын чадавхижуулах сургалтыг 2015 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр “Говь ресорт” амралтын газар дээр Санхүүгийн зохицуулах хороо, МИД төслийн ажилтнуудтай хамтран зохион явууллаа. Сургалтанд нийт 22 хүн хамрагдсан байна.

#### **Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын хүрээнд:**

Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар нь газрын дарга, хөрөнгө оруулалтын шинжээч, нөхөн төлбөрийн менежер зэрэг орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Өөрийн хөрөнгийн 15 тэрбум төгрөгийн 14.7 тэрбум төгрөгт 364 хоногийн хугацаатай 17 000 ширхэг Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) аваад байна.
2. Алдагдлаас хамгаалах сангийн 2014 оны эхний 5 тэрбум төгрөгийг холбогдох зохицуулалтын дагуу байршуулахаар банкуудаас хадгаламжийн хүүгийн санал авч Төрийн банк, ХААН банк, Худалдаа хөгжлийн банк, Хас банк зэрэг 4 банкинд тэнцүү хэмжээтэйгээр жилийн 14.4-16.5 хувийн хүүтэйгээр, хүүг нь сар бүр үйл ажиллагааны дансанд шилжүүлэх нөхцөлтэйгээр байршууллаа. Алдагдлаас хамгаалах сангийн 2015 оны санхүүжилтийн 2 тэрбум төгрөг 2015 оны 3 дугаар сарын 31-ны өдөр орж ирсэн ба банкуудаас хадгаламжийн хүүгийн санал авч Төрийн банк, ХААН банкинд жилийн 16.2-16.5 хувийн хүүтэйгээр жилийн хугацаатай гэрээ байгуулан байршууллаа.

#### **Санхүү, удирдлагын газрын үйл ажиллагааны хүрээнд:**

Санхүү, удирдлагын газар нь одоогоор газрын дарга, нягтлан бодогч, захиргааны ажилтан, гадаад хамтын ажиллагааны ажилтан, жолооч зэрэг орон тооны бүтээцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

1. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК санхүүгийн хувьд дүрмийн сан болон алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгө, харилцах дансны үлдэгдэлд нийтдээ 185.7 сая



төгрөгийн бодит хүүгийн орлоготой, 25.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажиллажээ.

2. 2015 оны эхний улиралд улсын төсвөөс санхүүжүүлсэн алдагдлаас хамгаалах сангийн 2.0 тэрбум төгрөгийг ТҮЗ-ийн шийдвэрийн дагуу Хаан болон Төрийн банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсан. Тайлант хугацаанд нийт 127.6 сая төгрөгийн хүүгийн орлоготой, үйл ажиллагааны зардалд 117.5 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 91.3 сая төгрөг зарцуулсан байна.
3. 2015 оны санхүүгийн тайланд 3 дугаар сарын 13-наас 20-ны өдөр хүртэлх хугацаанд “Алаг уул аудит” ХК-аар иж бүрэн аудит хийлгэсэн ба аудитлагдсан тайлант компанийн ТҮЗ-д танилцуулж холбогдох хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд Сангийн яам болон СБД-ийн санхүү, төрийн сан, татварын хэлтэст хүргүүллээ.
4. Гүйцэтгэх захирлын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 04/12 тоот тушаалаар компанийн хөдөлмөрийн дотоод журам батлагдан мөрдөгдөж байна. Мөн 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 04/13 тоот тушаалаар компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх журам болон МИД-ын 2015 оны борлуулалтын улиралд хийгдэх ажлын жагсаалтыг баталж гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.
5. Компанийн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргаж өгөх албан тушаалтнуудын жагсаалтыг баталж хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, ХАСХОМ-ийг бүртгэх албан тушаалтынг томилон ажиллуулж байна.
6. Компанийн хувийн хэрэгт байвал зохих баримт бичгийн жагсаалт гарган баримт бичиг нэг бүрийн бүртгэл хөтлөх, хадгалах албан тушаалтнуудыг үүрэгжүүлэн ажиллаж байна.
7. 2015 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 109.6 сая төгрөгийн бараа, 9.7 сая төгрөгийн ажил, 37.0 сая төгрөгийн үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг амжилттай зохион явууллаа.
8. “Худалдан авах ажиллагааны онолын үндэс, олон улсын туршлага, эрх зүйн орчин” сэдэвт сургалтанд 5 ажилтныг сурган мэргэшүүлж байна.
9. 2015 оны МИД-ын борлуулт болон компанийн бусад үйл ажиллагааг орон нутагтай холбох зорилгоор ажилтнууддаа бүс, аймгийг хуваарилан өгч орон нутгийн төрийн болон даатгалын компанийн төлөөлөгчидтэй холбогдон мэдээлэл, арга зүйгээр ханган ажиллаж байна.



Хавсралт

## Хувьцаа эзэмшигч

Ж.Эрдэнэбат. Сангийн сайд

## Төлөөлөн Удирдах Зөвлөл

1. Х.Ганцогт. ТУЗ-ийн дарга, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
2. Б.Нямаа. ТУЗ-ийн гишүүн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга
3. Л.Чой-Иш. ТУЗ-ийн гишүүн, ХХААЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
4. Р.Содхүү. ТУЗ-ийн гишүүн, Үндэсний статистикийн хорооны дэд дарга
5. М.Жалавдорж. ТУЗ-ийн гишүүн, Даатгагчдын төлөөлөл
6. Н.Баяртайхан. ТУЗ-ийн гишүүн, Даатгуулагчийн төлөөлөл
7. Н.Мандуул. ТУЗ-ийн гишүүн, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга
8. Б.Даажамба. ТУЗ-ийн гишүүн, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч
9. Ц.Түмэнхишиг. ТУЗ-ийн гишүүн, Хараат бус гишүүн
10. Б.Шаравсамбуу. ТУЗ-ийн гишүүн, Хараат бус гишүүн
11. Д.Лхагвадорж. ТУЗ-ийн гишүүн, Хараат бус гишүүн
12. Б.Ганболд. ТУЗ-ийн гишүүн, Хараат бус гишүүн
13. Л.Мөнхдэмбэрэл. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

## “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК

1. Б.Даажамба. Гүйцэтгэх захирлын орлон гүйцэтгэгч
2. Д.Дуулал. Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын дарга
3. Э.Ванчинхүү. Санхүү, удирдлагын газрын дарга
4. Ш.Түмэннаст. Захиргааны ажилтан, Санхүү, удирдлагын газар
5. Б.Ганцог. Нягтлан бодогч, Санхүү, удирдлагын газар
6. Х.Хос-Эрдэнэ. Эрсдэлийн шинжээч, Бизнес хөгжил, төслийн газар
7. Б.Билэгчулун. Нөхөн төлбөрийн менежер, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар
8. Г.Нямдаваа. Гадаад хамтын ажиллагааны ажилтан, Санхүү, удирдлагын газар



9. О.Сарантуяа. Даатгалын шинжээч, Давхар даатгалын газар
10. Б.Гэрэлтуяа. Хөрөнгө оруулалтын шинжээч, Хөрөнгийн удирдлага нөхөн төлбөрийн газар
11. Б.Эрдэнэбаяр. Андеррайтер, Давхар даатгалын газар
12. Б.Эрдэнэбаян. Төсөл санхүүжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Бизнесийн хөгжил, төслийн газар
13. С.Мягмарсүрэн. Жолооч, Санхүү, удирдлагын газар